



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/05

Арвайхээр сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Ажил мэргэжлийн чиг баримтаа олгох зарим арга хэмжээний тухай” А/200 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.4.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Насан туршийн боловсролын төвийн дэргэдэх “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим”-ыг түшиглэн орон нутагт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг тасралтгүй, чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА:



А.ИШДОРЖ

6223 11 0009

Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 01-ны өдрийн  
дугаар захирамжийн  
хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Т.Нарангарав (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүрэг гүйцэтгэгч)

Н.Чимэддорж-Ойдов (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүрэг гүйцэтгэгч)

Б.Норовсүрэн (аймгийн Насан туршийн боловсролын төвийн даргын үүрэг гүйцэтгэгч)

С.Санчир (Политехник коллежийн захирал)

С.Долгорсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Бүзмаа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Мөнгөншагай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

Ж.Сайнбилэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн)

А.Гомбодорж (Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн Нийгмийн түншлэл үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч)

Ц.Содномдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн)

Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: О.Эрдэнэцэцэг (аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш)

-оОо-